

PRODUCTION



**РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ
ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ**



**РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ДҮРЭМ, ЖУРМЫН ЭМХТГЭЛ**

УЛААНБААТАР - 2019

РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ОЮУТНЫ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Үйлвэрлэл Урлалын Политехник Коллежийн Оюутны зөвлөлийн зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, бүтэц зохион байгуулалт, дарга, зөвлөлийн гишүүд, тэдний эрх үүрэг, бүрэн эрхийн хугацаа, хүлээх хариуцлагатай холбоотой харилцааг энэ дүрмээр зохицуулна.

1.2 Оюутны зөвлөл нь суралцагчдын эрхийг хамгаалах, соёл, хүмүүжлийн арга хэмжээ зохион байгуулах үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн, төрийн бус байгууллага бөгөөд өөрийн билэгдэл туг, тэмдэг, тамга, сүлд дуу, үнэмлэх, уриа, хэвлэмэл хуудас, самбар болон хувцастай байж болно.

ХОЁР. ОЮУТНЫ ЗӨВЛӨЛИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

21 Үйлвэрлэл Урлалын Политехник Коллежийн Оюутны зөвлөлийн эрхэм зорилго нь: Суралцагчдын эрх ашгийг хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх, сургуулийн захиргаа, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, суралцагчдын бие даан хөгжих бүхий л бололцоог дэмжин ажиллана.

22 Үйлвэрлэл Урлалын Политехник Коллежийн Оюутны зөвлөлийн үндсэн чиглэл:

2.2.1 ҮҮПК-ийн дүрмүүд, Төрийн бус байгууллагын тухай хууль, тэдгээртэй холбоотой бусад актад нийцүүлэн суралцагчдын дунд эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа, урлаг, спорт, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагаа явуулна.

2.2.2 Суралцагчдын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор мэргэжлийн болон сонирхлын клуб, дугуйлан ажиллуулна.

2.2.3 Монголын оюутны хөдөлгөөний эв нэгдлийг хамгаалан хөгжүүлэх, оюутны байгууллагын хамтын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллах, мэдээлэл солилцох, санал бодлоо илэрхийлэх бололцоог бүрдүүлнэ.

2.2.4 Сургуулиас зохион байгуулж буй сургалт, соёл хүмүүжлийн үйл ажиллагааны зохион байгуулалтад дэмжин туслаж, манлайлах үүрэгтэй оролцоно.

ГУРАВ. ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

31 Оюутны зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, сайн дурын үндсэн дээр өөрийн хүсэлтээр оюутны зөвлөлд нэгдсэн гишүүдээс бүрдэнэ.

3.1.1 Оюутны зөвлөл, шинэ гишүүд нь Сургалтын албаны саналаар сонгогдох бөгөөд 15 хүний бүрэлдэхүүнтэй байна.

32 Оюутны зөвлөлийн дарга, түүний бүрэн эрх

3.2.1 Оюутны зөвлөлийн дарга нь зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, төлөвлөгөөт ажлуудыг зохион байгуулах үүрэг бүхий сонгуульт ажилтан юм.

3.2.2 Оюутны зөвлөлийн даргын бүрэн эрхийн хугацаа нэг жил байна. Зөвлөлийн тэргүүнийг улируулан сонгож болно.

3.2.3 Зөвлөлийн даргын бүрэн эрх нь шинэ тэргүүн сонгогдсоноор дуусгавар болно.

33 Оюутны зөвлөлийн дарга нь дараах эрхийг эдэлнэ:

3.3.1 Оюутны зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулах

3.3.2 Оюутны зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагааг албан ёсоор нээх

3.3.3 Оюутны зөвлөлийн гишүүдэд үүрэг, даалгавар өгөх

3.3.4 Оюутны зөвлөлийн гишүүдээс шагнал, урамшуулал, хөнгөлөлтөд нэр дэвшүүлэх

3.3.5 Оюутны зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх, бүрэн эрхийг нэг жилээр сунгах

3.3.6 Хурлын шийдвэрийг батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох

3.3.7 Сургуулийн захиргаанд хурлын шийдвэрийг хүргүүлж, зохих асуудлыг шийдвэрлүүлэх

34 Оюутны зөвлөлийн дарга нь дараах үүргийг хүлээнэ:

3.4.1 Сургалтын албанаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх, хариуцлага хүлээх

3.4.2 Оюутны зөвлөлийн үйл ажиллагааг байнгын тогтвортой явуулж, сургуулийн хамт олонд нээлттэй байлгах

3.4.3 Оюутны зөвлөлийн үйл ажиллагаанд хэрэглэж байгаа эд хөрөнгийг хариуцах, хүлээлгэн өгөх

3.4.4 Оюутны зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг хүндэтгэн үзэж, хэрэгжүүлэх бололцоог хангах, хамтран ажиллах

3.4.5 Бусад сургуулийн оюутны зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

3.4.6 Үүрэгт ажлаа бүрэн гүйцэтгэж чадахгүй бол өөрийн хүсэлтээр даргын албан тушаалаас чөлөөлөгдөх

35 Оюутны зөвлөлийн гишүүд нь дараах эрх эдэлнэ:

3.5.1 Тодорхой асуудал хэлэлцүүлэхээр зөвлөлд саналаа өргөн мэдүүлэх

3.5.2 Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт асуух, хариулт авах, дүгнэлт гаргах, санал өгөх

3.5.3 Зөвлөлийн сонгуульт албан тушаалд сонгогдох, тэдгээрт өөрийн нэрийг дэвшүүлэх

3.5.4 Суралцагчдад сургуулийн дотоод журмыг сахиулж, шаардлага тавих, биелүүлээгүй тохиолдолд Сургалтын албанд мэдэгдэж асуудлыг шийдвэрлүүлэх

36 Оюутны зөвлөлийн гишүүд нь дараах үүрэг хүлээнэ:

3.6.1 Оюутны зөвлөлийн хуралдаанд тогтмол оролцож, олонхын саналаар шийдвэрлэгдсэн асуудлыг хүндэтгэх, сахин биелүүлэх

3.6.2 Зөвлөлийн гишүүний нэр төрд харш аливаа үйлдэл хийхгүй байх, ёс зүйн хэм хэмжээг чанд сахих

3.6.3 Зөвлөлийн гишүүний хувьд үг хэлэх, шаардлага тавих, санал гаргах, дүгнэлт хийхдээ асуудалд нотолгоотой, хариуцлагатай хандах

3.6.4 Зөвлөлийн ээлжит хурлыг шалтгаангүйгээр таслахгүй, хоцрохгүй байх

3.6.5 Оюутны зөвлөлийн журмаар хүлээсэн үүргээ хүндэтгэх, зөвлөлийн үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох

3.6.6 Олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд өөрийн сургуулийн оюутнуудын ашиг сонирхлыг нэн тэргүүнд баримтлах, төлөөлөн хамгаалах

37 Оюутны зөвлөлийн хуралдаан:

37.1 Хуралдааныг сард 2 удаа зохион байгуулах бөгөөд сонгогдсон бүх төлөөлөгчдийн гуравны хоёроос дээш хувь нь ирсэн тохиолдолд хүчинтэй байна.

37.2 Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна.

37.3 Хуралдаанаар зөвлөлийн үйл ажиллагаа болон суралцагчидтай холбоотой аливаа асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд зөвлөлийн дарга, тэргүүлэгчдийн тухай санал хүсэлт, бүтэц зохион байгуулалт, дүрэмд өөрчлөлт оруулах, цаашдын зорилтын талаарх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

37.4 Хуралдаанаар зөвлөлийн гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийн үр дүнг тооцож, хийсэн ажлаа дүгнэнэ.

3.8 Үйл ажиллагааны үндсэн зарчим:

3.8.1 Сургуулийн нийгмийн ажилтан Оюутны зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагаанд зөвлөн чиглүүлэх, туслах үүрэгтэй оролцоно.

3.8.2 Оюутны зөвлөл үйл ажиллагаандаа ардчилсан зарчмыг удирдлага болгож, оюутан суралцагчдын нийтлэг эрх, ашгийг хамгаалж нас, бие, сэтгэхүйн онцлогийг харгалзан ажиллана.

3.8.3 Оюутны зөвлөл нь үйл ажиллагааны үндсэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд сургалтын алба, нийгмийн ажилтан, нийгмийн түншлэл хариуцсан ажилтан, багш нартай хамтран ажиллана.

ДӨРӨВ. БУСАД

4.1 Үйл ажиллагааны хагас болон бүтэн жилийн ажлаа Сургалтын албаны хуралд тайлагнана.

4.2 Хичээлийн жилд зохион байгуулсан үйл ажиллагааны бүх төлөвлөгөө, тайлан бусад холбогдох бичиг баримтыг архивын нэгж бүрдүүлж архивт хүлээлгэж өгнө.